BULIGAAR
BOVINE SKIN TANNERY
EST. 1934

# “БУЛИГААР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 19 өдөр Дугаар 08/24 Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг сонгох тухай**

МУ-ын Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх заалт, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 10 дугаар зүйлийн 10.13, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Нэг. Булигаар ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 100 хувийн саналаар А.Энхмэндийг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар сонгосугай.

Хоёр. Компанийн тухай хууль, компанийн дүрэм, журмаар тогтоосон эрх, үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ТУЗ-ийг удирдан зохион байгуулж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /А.Энхмэнд/-д үүрэг болгосугай.

BULIGAAR JSC
БУЛИГААР ХК
УЛААНБААТАР ХОТ
ХТҮ5406 9022080051 2039184

ХУРЛЫН ДАРГА Б.АНХБОЛД

BULIGÁR
BOVINE SKIN TANNERY
EST. 1934

# “БУЛИГААР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 19 өдөр Дугаар 09/24 Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодыг байгуулах тухай**

МУ-ын Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1, 81.2 дахь заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.31 дэх заалт, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 10 дугаар зүйлийн 10.13, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Нэг. Булигаар ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | |
|---|---|
| Аудитын хорооны дарга: | Хараат бус гишүүн Ч.Нямдорж |
| Гишүүд: | Хараат бус гишүүн Т.Болд |
| | Ердийн гишүүн Б.Анхболд |
| Нэр дэвшүүлэх хорооны дарга: | Хараат бус гишүүн Т.Болд |
| Гишүүд: | ТУЗ-ийн дарга Б.Энхмэнд |
| | Ердийн гишүүн Ц.Мөнхлхагва |
| Цалин урамшууллын хорооны дарга: | Хараат бус гишүүн Ж.Эрдэнэбат |
| Гишүүд: | Ердийн гишүүн Д.Гансүх |
| | Ердийн гишүүн Б.Баянжаргал |
| | Ердийн гишүүн Б.Баттүшиг |

Хоёр. Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ТУЗ-д тогтмол танилцуулж ажиллахыг Аудитын хорооны дарга /Ч.Нямдорж/, Нэр дэвшүүлэх хорооны дарга /Т.Болд/, Цалин урамшууллын хорооны дарга /Ж.Эрдэнэбат/ нарт тус тус үүрэг болгосугай.

BULIGAAR JSC
БУЛИГААР ХК
УЛААНБААТАР ХОТ
ХТҮ5403 9022080051 2039184

ХУРЛЫН ДАРГА Б.АНХБОЛД

BULIGAAR
BOVINE SKIN TANNERY
EST. 1934

# “БУЛИГААР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 19 өдөр Дугаар 10/24 Улаанбаатар хот

## Гүйцэтгэх захирлыг томилох тухай

МУ-ын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дэх заалт, Булигаар ХК-ийн компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.41, 7.45 дахь заалт, ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн дүгнэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Нэг. “Булигаар” ХК-ийн гүйцэтгэх захирал Батчулуун овогтой Анхболдыг чөлөөлсөнтэй холбогдуулан 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн “Булигаар” ХК-ийн Гүйцэтгэх захирлаар Бямбабаяр овогтой Баттүшиг /Регистрийн дугаар: УХ94041119/-ийг томилсугай.

Хоёр. Гүйцэтгэх захиралд “Булигаар” ХК-ийн нэрийн өмнөөс хууль, тогтоомж болон компанийн дүрэм, гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээнд заасан эрхийн хүрээнд гэрээ хэлцэл байгуулах итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй бөгөөд компанийн эрх ашигт нийцэх албан бичиг баримтад компанийг төлөөлөн гарын үсэг зурах эрхийг үүгээр олгосугай.

Гурав. Гүйцэтгэх захирал Б.Баттүшигтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулж, ажлын байрны тодорхойлолтыг танилцуулахыг ТУЗ-ийн дарга /А.Энхмэнд/-д даалгасугай.

Гурав. Гүйцэтгэх захирлын мэдээллийг Улсын бүртгэлд бүртгүүлж компанийн улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэл хийлгэхийг Гүйцэтгэх захирал /Б.Баттүшиг/-д даалгасугай.

BULIGAAR JSC
БУЛИГААР ХК
УЛААНБААТАР ХОТ
ХТҮ5406 9022080051 2039184

ХУРЛЫН ДАРГА Б.АНХБОЛД